



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/946

Улаанбаатар хот

### Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.12 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 96 дугаар тогтоолын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх тохижилт, бүтээн байгуулалтын ажлын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээг дүрмээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг “Нийслэлийн Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах 1,680,000,000 (нэг тэрбум зургаан зуун наян сая) төгрөгийг нийслэлийн 2023 оны төсөвт тусгасан “Хот тохижилтын бусад арга хэмжээний зардал”-аас гаргахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (М.Баяраа)-нд, холбогдох хууль, журмын дагуу хянан, гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.



संस्कृत विश्वविद्यालय

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
08 дугаар сарын 22-ны өдрийн  
захирамжийн  
хавсралт



ТОХИЖИЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН  
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (БХД)	2023	120.0	120.0
2	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (НД)	2023	120.0	120.0
3	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (БНД)	2023	120.0	120.0
4	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (СБД)	2023	240.0	240.0
5	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (ЧД)	2023	360.0	360.0
6	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (СХД)	2023	360.0	360.0
7	Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил (БЗД)	2023	360.0	360.0
	ДҮН		1,680.0	1,680.0